



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2011 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 166

Улаанбаатар хот

Г “Хялганат” ХК-ийн нэгдмэл сонирхолтой 7  
хувьцаа эзэмшигчдээс гаргасан  
тендер саналыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, Компанийн тухай хуулийн 58.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хялганат” ХК-ийн нийт гаргасан 8091 ширхэг энгийн хувьцааны 83.19 хувь буюу 6731 ширхэг хувьцааг нэгдмэл сонирхолтойгоор эзэмшигч С.Шаравдорж, Б.Ууганбаяр, Д.Булганчимэг нараас тус хувьцаат компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа нийт хувьцааны 16.81 хувь буюу 1360 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 5000 /таван мянган /төгрөгөөр худалдан авч тус компанийг 100 хувь эзэмшихээр тендер санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2011 оны 6 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоногоор тогтоосугай.

2. Холбогдох хууль, журмын дагуу тендер саналаа нийтэд сурталчилж, хуулиар хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлж ажиллахыг С.Шаравдорж, Б.Ууганбаяр, Д.Булганчимэг нарт үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Үнэт цаасны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Дүгэржав/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-д тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН